

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар A/51

Арвайхээр сум

Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн “Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт батлах тухай” А/298 дугаар тушаал, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ОЮУНТУЯА




АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг

Албан тушаалын нэр:

Нэгдсэн эмнэлгийн захирал

Ажлын цаг

Ажлын өдөр 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

ТҮЭМ-8

Ажлын байрны албан ёсны байршил:

Өвөрхангай аймгийн Хархорин сум

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сумын хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон үндсэн мэргэшлээр лавлагaa шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, чадварлаг хүний нөөцийг бурдүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиг үүргийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
2. Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон үндсэн мэргэшлээр лавлагаа шатлалын тусlamж, үйлчилгээг үзүүлэх, зарим төрөлжсөн мэргэшлээр лавлагаа шатлалын нэн шаардлагатай тусlamж үйлчилгээг нэмэлтээр үзүүлэх;
3. Байгууллагын гүйцэтгэлийн болон стратегийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүгийн тогтвортой, үр ашигтай байдлыг хангах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах;
4. Бусад байгууллагад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас бусад мэргэшлийн чиглэлээр зөвлөгөө авах;
5. Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцах, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх;

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хариуцах, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Хууль тогтоомжийг мөрдөж ажилласан байна	Г, Х, Ш
	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эмнэлгийн хэмжээнд зохион байгуулах	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш
	Эрүүл мэндийн урт, дунд, хугацааны бодлого, хөтөлбөр, стратеги, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг байгууллагын түвшинд хэрэгжүүлэх, орон нутгийн бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэшлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г, Х, Ш
	Үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн үндсэн ба нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээг хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нөөцөөр хангах	Хууль тогтоомж, заавар, журам, стандартад нийцсэн байна.	Г, Х, Ш
	Үйлчлэх хүрээний хүн амд үндсэн мэргэшлийн тусlamж, үйлчилгээг хууль,		Г, Х, Ш

	стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх	Хууль тогтоомж, заавар, журам, стандартад нийцсэн тусlamж үйлчилгээг чанартай үзүүлсэн байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	Үйлчлэх хүрээний хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан зарим нэн шаардлагатай төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээг хууль, стандарт, дүрэм, журам, эмнэл зүйн заавар, удирдамж, тушаал шийдвэрийн дагуу үзүүлэх	Г, Х, Ш	
	Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, чанарын үзүүлэлтийг ханган ажиллах	Г, Х, Ш	
	Эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Эрсдэлийн үнэлгээний үр дүнг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлаар нотолгоонд суурилсан санал боловсруулах, холбогдох байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх	Шинээр нэвтрүүлсэн оношилгоо, эмчилгээний үр дүн	Г, Х, Ш
	Гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдал, нөөцийг бүрдүүлж, хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг зохион байгуулах	Онцгой байдлын үеийн хяналт шалгалт, төлөвлөлт хэрэгжсэн байна.	Г, Х, Ш
	Үйлчилгээний соёлыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш
	Эрүүл мэндийг дэмжих, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгааг ойлгомжтой, чанартай олон сувгаар хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулах	Иргэд, олон нийтэд сурталчилж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Г, Х, Ш
	Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааг тогтмолжуулж, эмгэгийг эрт илрүүлэх үзлэг оношилгоог зохион байгуулах	Үзлэг, оношлогоонд хамрагдалтын хувийг хангасан байна.	Г, Х, Ш
	Байгууллагын стратеги төлөвлөгөөг үндэсний болон салбарын урт, дунд хугацааны бодлого хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж тусlamж, үйлчилгээний тэгш байдал, чанар, хүртээмж, аюулгүй	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш

3 дугаар зорилтын хүрээнд	байдлыг хангахад чиглүүлэн хэрэгжүүлэх		
	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын стратеги төлөвлөгөө болон харьяалах дээд шатны байгууллагын тухайн жилийн зорилттой уялдуулан жил бүр батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш
	Хүний нөөцийн хэрэгцээг өөрийн байгууллагын түвшинд тооцон төлөвлөлт хийх, хүний нөөцийг бүрдүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг хэгэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Хүний нөөцийг хөгжүүлэх, сургах, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна.	Г, Х, Ш
	Төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг үр ашигтай зарцуулах, тогтвортой байдлыг хангаж, өр авлагагүй ажиллах	Хууль тогтоомжийг мөрдөж, хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
4 дүгээр зорилтын хүрээнд	Байгууллагын хөгжил, хүний нөөцийг чадавхижуулах, тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, мэдээллийн технологийг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээг өргөжүүлэх чиглэлээр олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, бусад байгууллагуудтай хууль тогтоомжийн хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэх	Хамтын ажиллагааны үр дүн дээшилсэн байна.	Г, Х, Ш
	Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чиглэлээр аймгийн бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэшлийн арга зүйгээр хангах		Г, Х, Ш
	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бусад лавлагаа төвөөс мэргэшлийн арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллах	Мэргэжлийн байгууллагатаа хамтран ажиллаж, мэргэшил арга зүйгээр хангасан байна.	Г, Х, Ш
5 дугаар зорилтын хүрээнд	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед хүн амын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр аймгийн Онцгой байдлын газар, орон нутгийн захиргааны байгууллага, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэшлийн арга зүйн дэмжлэг үзүүлэх	Мэргэжил, мэргэшил арга зүйгээр	Г, Х, Ш

	хяналт тавих	хангасан байна.	
	Хууль, тогтоомж, бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал шийдвэр гаргах, эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Батлагдсан төсөв, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг зохицуулан ажиллах	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг үнэлж дүгнэх, ажилтнуудад ажлын үр дүнгээр нь урамшуулал олгох, хариуцлага тооцох	Хууль тогтоомж, дүрэм журмын дагуу үнэлж дүгнэсэн байна.	Г, Х, Ш
	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х, Ш
	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах нөхцлийг бүрдүүлэх	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Байгууллагын үйл ажиллагааг үе шаттайгаар бүрэн цахимжуулах ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах	Хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байна.	Г, Х, Ш
	Томилох эрх бүхий ажилтны холбогдох шийдвэрийн дагуу гадаад, дотоод томилолтоор ажиллах	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Г, Х, Ш
	Хөдөлмөрийн гэрээ, хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн байна.	Г, Х, Ш

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- Анагаах ухаан /0912/.

Мэргэшил		<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэн байх - Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаалт эрхэлдэгтгүй байх
Туршлага		Эрүүл мэндийн салбарт 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс эрүүл мэндийн байгууллагад 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх.
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, тайлгах; - нэгжийн үйл ажиллагаан дахь эрсдэлийн нөхцөл байдлыг тодорхойлох, эрсдэлийг илрүүлэх, шинжлэх, дүгнэх, эрсдэлийн арга хэмжээний хувилбарыг боловсруулах, хяналт тавих; - нэгжийн албан хаагчдад ажил үүргийг тэнцвэртэй, оновчтой хуваарилах, зөвлөх, чиглүүлэх; - албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих; - үл ойлголцол, саналыг зөрүүг эв зүйгээр зохицуулах бусад.
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - мэдээлэлд тулгуурлан, бүтэц, чиг үүргийн болон салбарын системийн шинжилгээ хийх; - харьцуулсан судалгаа хийх, судалгааны үр дүнг үнэлэх, тайлбарлах; - шийдвэрийн шууд болон шууд үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - хуульд нийцсэн оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах; - аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах, санал боловсруулах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд аливаа асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эзрэг, сөрөг үр дагаврын талаар тайлбарлах, зөвлөх; - бусад.
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> - байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, хувийн зан төлөв, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэр дуурайлал үзүүлэх; - нэгжийн үйл ажиллагаанд шинэлэг санаа, үйлчилгээг нэвтрүүлэх, албан хаагчдын шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг манлайлах; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;

		<ul style="list-style-type: none"> - харилцааны орчин үеийн арга хэлбэрийг ашиглах, мэдээллийг хүргэх; - албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - комьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах.
--	--	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Албан тушаалд шууд харьялан
удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Батлагдсан бүтэц, орон тоогоор

Бусад харилцах субъект:

- Яам, агентлагын холбогдох удирдлага, мэргэжилтнүүд;
- Аймгийн Эрүүл мэндийн газар;
- Орон нутгийн ИТХ, ЗДТГ, холбогдох албан тушаалтан;
- Бусийн оношилгоо, эмчилгээний төв;
- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бусад эрүүл мэндийн байгууллага;
- Төрийн болон төрийн бус байгууллага;
- Иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон байгууллагын
шийдвэр:

Албан тушаал:
УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Н.Оюунтуяа

2024 оны сарын -ны өдөр

Байгууллагын нэр:
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Шийдвэрийн огноо:
Дугаар:.....

VI. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ БАТАЛСАН:

Байгууллагын нэр: ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2024 оны 10 дугаар сарын 16. -ны өдөр

Дугаар: 1/51

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Н.Оюунтуяа*/Н.ОЮУНТУЯА/

2024 оны 10 дүгээр сарын 16. -ны өдөр

---оо---